



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/715

Булган сум

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх
тусгай зөвшөөрлийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох цэгийн нэрсийг 1 дүгээр, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр солих цэгийн нэрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/122 дугаар захирамжийн Ц.Нямдаваа захиралтай “Гранд майнд” ХХК-ийн “Хужир толгой” хүнсний дэлгүүртэй холбогдох заалтыг хүчингүйд тооцсугай.

3.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д тус тус даалгасугай.

4.Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010998

2025 оны 11 сарын 10 өдөр


Аймгийн Засаг даргын 2025 оны
11 дүгээр сарын 10-ны/ний өдрийн
№715 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Баян-Агт сум 6-р баг	“Хан нажин Ургийнхан” ХХК	Д.Амарбат	Хүнсний дэлгүүр	“Тэгш”
2	Хангал сум Хялганат тосгон 4-р баг	“Баруун тайга” ХХК	Д.Одгэрэл	“Мини маркет” хүнсний дэлгүүр	“Мини эргэл маркет”
3	Хангал сум 2-р баг “Чулуутын ам”	“Өлзийт хангал” ХХК	Б.Үерхэл	Амралтын газрын дэргэдэх зоогийн газар	“Чулуут ам лодж”
4	Тэшиг сум 5-р баг	“Бадмаанямбуу Уул” ХХК	Б.Мөнгөнсүх	Хүнсний дэлгүүр	“Сөрт”
5	Тэшиг сум 5-р баг 5-1 тоот Нийт-5	“Ёлтын зүүн баргил” ХХК	Б.Баасанжав	Хүнсний дэлгүүр	“Залман”

Аймгийн Засаг даргын 2025 оны
 11 дүгээр сарын 10-ны өдрийн
 117/15 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН НЭР СОЛИХ ЦЭГИЙН НЭР**

д/д	Сумын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Үйлчилгээний төрөл	Оноосон нэр	Шинээр тусгай зөвшөөрөл эзэмших		Оноосон нэр
		Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр			Аж ахуйн нэгжийн нэр, албан ёсны хаяг	Захирлын овог, нэр	
1	2	3	4	5	6	7	8	9
1	Булган сум 6-р баг, Хужир толгой Нийт-1	“Гранд майнд” ХХК	Ц.Нямдаваа	Хүнсний дэлгүүр	“Хужир толгой”	“Хорол тоонот” ХХК 6-р баг, 18-1804 тоот	Ц.Нямдаваа	“Хужир толгой”